



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 234

Улаанбаатар хот

### Журам шинэчлэн батлах тухай

Архивын тухай Монгол Улсын хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 53 дугаар тогтоол “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Үндэсний Архивын газрын даргын 2007 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 59 дүгээр тушаал “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”, “Монголын Хөрөнгийн Бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.9, 8.10.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Архивын үйл ажиллагааны журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталж 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
2. Архивын үйл ажиллагааны журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2002 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 65 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Албан хэрэг хөтлөлтийн журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2014 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 68 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалын 3 дахь заалттай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2014 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 68 дугаар тушаалын 1 дэх заалтад “Баримт бичгийн эргэлт, түүнд тавих хяналтын тухай журмыг дөрөвдүгээр хавсралтаар” гэснийг хассугай.
5. “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Архивын үйл ажиллагааны журам”, “Албан хэрэг хөтлөлтийн журам” тус тус шинэчлэн батлагдсантай холбогдуулан журмуудыг нийт ажилтнуудад танилцуулах ажлыг зохион байгуулах, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа аж ахуйн алба /Ж.Нарантуяа/-д, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хэрэг эрхлэх газар /Б.Батаа/-д тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР